



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2019 оны 9 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 9%-иар буюу 911 сая ам.доллараар өсч 10,545 сая ам.доллар байв. Үүнд экспорт 13%-иар буюу 663 сая ам.доллараар, импорт 6%-иар буюу 248 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 416 сая ам.доллараар өсч 1,347 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 9 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	7,714	9,634	10,545	1,920	25%	911	9%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	4,583	5,283	5,946	700	15%	663	13%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	3,131	4,351	4,599	1,220	39%	248	6%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	1,452	932	1,347	(520)	-36%	416	45%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 230 сая ам.доллараар өсч 1,426 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65% буюу 6,825 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 1,312 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 0.2%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 7%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2019 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8%-иар, өмнөх сараас 10%-иар буурч 1.807-д хүрлээ. Худалдааны нөхцлийн индекс өмнөх сараас муудахад чулуун нүүрсний экспортын үнийн бууралт голлон тайлбарлагдаж байна.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 13%-иар буюу 663 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 11 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.3 нэгж хувиар, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		4,044	88%	4,672	4,672	88%		5,276	89%	628	16%	14%	604	13%	11%
1.1. Эзсийн хүдэр, баяжмал	1,084	1,155	25%	1,073	1,488	28%	1,066	1,421	24%	332	29%	7%	(67)	-4%	-1%
1.2. Чулуун нүүрс	25,532	1,724	38%	27,027	2,122	40%	28,629	2,435	41%	398	23%	9%	312	15%	6%
1.3. Боловсруулаагүй нефть	5,636	272	6%	4,812	316	6%	4,842	272	5%	44	16%	1%	(44)	-14%	-1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	4,309	228	5%	5,315	240	5%	6,134	422	7%	12	5%	0%	182	76%	3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	9,883	403	9%	3,432	144	3%	7,464	344	6%	(258)	-64%	-6%	200	138%	4%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	91	134	3%	92	153	3%	101	145	2%	20	15%	0%	(8)	-5%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	216	55	1%	345	116	2%	500	155	3%	61	110%	1%	39	34%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5	27	1%	4	36	1%	4	37	1%	9	31%	0%	1	3%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	5	0%	0	5	0%	0	5	0%	(0)	-4%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	1	0%	0	-	0%	(0)	0%	0%	(1)	0%	0%
1.11. Бусад	264	39	1%	374	50	1%	102	40	1%	11	29%	0%	(11)	-21%	0%
2. Мал аж, ахуй	250	312	7%	296	388	7%	247	402	7%	76	24%	2%	14	4%	0%
2.1. Амьд мал, малын мах	14	26	1%	20	46	1%	18	37	1%	20	78%	0%	(9)	-19%	0%
2.2. Арьс, шир	216	17	0%	252	13	0%	208	11	0%	(4)	-26%	0%	(1)	-12%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	6	0%	0	6	0%	1	24%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	7	244	5%	8	299	6%	8	327	6%	55	23%	1%	28	9%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	13	18	0%	12	22	0%	11	19	0%	3	18%	0%	(3)	-15%	0%
2.6. Бусад	1	2	0%	3	3	0%	3	2	0%	1	35%	0%	(1)	-24%	0%
3. Газар тариалан	140	9	0%	26	5	0%	34	8	0%	(3)	-40%	0%	2	47%	0%
4. Аж үйлдвэрлэл	333	217	5%	182	217	4%	305	260	4%	(0)	0%	0%	43	20%	1%
4.1. Хүнс	16	65	1%	16	47	1%	17	42	1%	(18)	-28%	0%	(5)	-11%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	21	0%	1	25	0%	1	33	1%	3	15%	0%	8	32%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	2	12	0%	2	18	0%	2	13	0%	7	58%	0%	(5)	-29%	0%
4.4. Уул уурхай	26	80	2%	43	82	2%	118	81	1%	2	3%	0%	(2)	-2%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	2	0%	0	1	0%	1	203%	0%	(1)	-69%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	34	1%	2	39	1%	1	87	1%	5	16%	0%	47	121%	1%
4.7. Бусад	288	5	0%	118	4	0%	166	5	0%	(1)	-24%	0%	(1)	38%	0%
5. Бусад	1	1	0%	0	1	0%	0	1	0%	0	30%	0%	0	-26%	0%
Нийт дүн		4,583		5,283			5,946			700	15%		663	13%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 9 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	325		279		604	13%
1.1. Эзсийн хүдэр, баяжмал	(9)	54x	(58)	87%	(67)	-4%
1.2. Чулуун нүүрс	136	44%	176	56%	312	15%
1.3. Боловсруулаагүй нефть	2	-4%	(46)	104%	(44)	-14%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	56		126		182	76%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	186	93%	14	7%	200	138%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	12	-147%	(21)	247%	(8)	-5%
1.7. Жонош, лейцит, нефелинт	48	122%	(9)	-22%	39	34%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(2)	-154%	3	254%	1	3%
1.11. Бусад	(106)	994%	95	-894%	(11)	-21%
2. Мал аж, ахуй	(33)		47		14	4%
2.1. Амьд мал, малын мах	(6)	67%	(3)	33%	(9)	-19%
2.2. Арьс, шир	(2)	165%	1	-65%	(1)	-12%
2.3. Малын өлөн гэдэс	(0)	-11%	0	111%	0	0%
2.4. Ноолуур	(23)	-84%	51	184%	28	9%
3. Газар тариалан	2		1		2	47%
4. Аж үйлдвэрлэл	8		35		43	20%
5. Бусад	0		(0)		(0)	-26%
Нийт дүн	302		362		663	13%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм

2019 оны эхний 9 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 302 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 362 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 127 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 119 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалж 8 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 35 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 9 дүгээр сард 1,508 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26%-иар, өмнөх сараас 0.3%-иар тус тус өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,759; 93 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 5%-иар буурсан бол төмрийн хүдэр 36%-иар өссөн, өнгөрсөн сараас зэсийн үнэ 1%-иар өсч, төмрийн хүдэр өмнөх сарын түвшинд байлаа. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 9 дүгээр сард 82 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2%-иар өссөн бол өмнөх сараас 2%-иар буурлаа.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Импорт 2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 248 сая ам.доллараар өсөв. Импортын 6 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 5 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 1 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
Хэрэглээний бүтээгдэхүүн		929	30%	1,182	27%	1,230	27%	253	27%	8%	49	4%	1%		
Түргэн эдлэгтэй	624	518	17%	714	617	14%	666	621	14%	99	19%	3%	4	1%	0%
Хүнс	280	361	12%	343	429	10%	315	436	9%	68	19%	2%	7	2%	0%
Эм, тариа	2	65	2%	2	82	2%	2	77	2%	17	27%	1%	(5)	-6%	0%
Бусад турзан эдлэгтэй бараа	342	92	3%	369	106	2%	349	108	2%	13	15%	0%	2	2%	0%
Удаан эдлэгтэй	170	411	13%	181	565	13%	239	609	13%	154	37%	5%	45	8%	1%
Гутал, хувцас, цүнх	54	45	1%	43	54	1%	50	50	1%	9	20%	0%	(4)	-7%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	64	65	2%	76	84	2%	127	80	2%	18	28%	1%	(4)	-4%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	252	8%	1	367	8%	1	444	9%	114	45%	4%	48	13%	1%
Бусад удаан эдлэгтэй бараа	51	49	2%	60	60	1%	61	65	1%	12	24%	0%	4	7%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	837	1,196	38%	1,140	1,797	41%	989	1,999	43%	601	50%	19%	203	11%	5%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	20	751	24%	25	1,127	26%	21	1,315	29%	376	50%	12%	188	17%	4%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	214	7%	1	353	8%	2	473	10%	139	65%	4%	120	34%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	19	537	17%	24	775	18%	19	842	18%	237	44%	8%	67	9%	2%
Барилгын материал	493	316	10%	621	512	12%	795	523	11%	196	62%	6%	11	2%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	49	128	4%	31	157	4%	36	161	4%	29	22%	1%	4	3%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	1,061	405	13%	1,185	553	13%	1,365	507	11%	147	36%	5%	(45)	-8%	-1%
Хүнсний орц	32	15	0%	271	73	2%	39	19	0%	58	388%	2%	(55)	-75%	-1%
Химийн бүтээгдэхүүн	140	81	3%	154	92	2%	170	91	2%	11	14%	0%	(1)	-1%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	30	16	1%	57	22	1%	58	21	0%	6	36%	0%	(1)	-3%	0%
Цахилгаан эрчим хүч	2	100	3%	1	105	2%	1	108	2%	6	6%	0%	2	2%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	0	1	0%	1	1	0%	(0)	-8%	0%	0	5%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	631	193	6%	656	260	6%	720	268	6%	66	34%	2%	8	3%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	1,061	595	19%	1,185	815	19%	1,365	858	19%	219	37%	7%	43	5%	1%
Дизель түлш	632	326	10%	630	414	10%	824	507	11%	88	27%	3%	94	23%	2%
АИ-92, АИ-95	276	162	5%	271	191	4%	350	211	5%	29	18%	1%	20	10%	0%
А-80 болон бусад	153	107	3%	283	210	5%	190	140	3%	102	95%	3%	(70)	-33%	-2%
Бусад	12	6	0%	13	5	0%	143	4	0%	(0)	-5%	0%	(1)	-18%	0%
Нийт дүн		3,131		4,351		4,599		1,220	39%	248	6%				

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2019 он эхний 9 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	53	109%	(4)	-9%	49	4%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	108	53%	95	47%	203	11%
Аж үйлдвэрлэлийн орц	(67)		21		(45)	-8%
Нефтийн бүтээгдэхүүн	99	227%	(55)		43	5%
Дизель түлш	119	127%	(26)	-27%	94	23%
АИ-92, АИ-95	47	241%	(28)	-141%	20	10%
А-80 болон бусад	(68)	97%	(2)	3%	(70)	-33%
Бусад	4		(5)		(1)	-18%
Нийт дүн	197	79%	51	21%	248	6%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 203 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 49 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 43 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 45 сая ам.доллараар буурснаар нийт импорт 248 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурсан бол өмнөх сараас 1 хувиар өсч тонн тутамд 624 ам.долларт хүрэв.